



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/1341.

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,543,200.0 (арван гурван сая таван зуун дөчин гурван мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Нийслэлийн хүүхдийн 45,147,191,268,304 дүгээр цэцэрлэгийн балансас тус тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн хүүхдийн 22 дугаар цэцэрлэг (З.Цацрал)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн хүүхдийн 45 дугаар цэцэрлэг (П.Сайнбилэг), 147 дугаар цэцэрлэг (Х.Чимэдцэрэн), 191 дүгээр цэцэрлэг (Б.Пүрэвцэрэн), 268 дугаар цэцэрлэг (Н.Бяцханцэцэг), 304 дүгээр цэцэрлэг (Б.Гандулам)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюунмаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн АУУ дугаар тушаалын хвсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: 22 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалта д орсон огноо	Хэмжи х нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2025.09.30/	Шилжүүлэн авах байгууллага	
1	1-р хоолны тогоо	Орос	2020	ш	1	3,905,000.00	3,905,000.00	3,904,999.80	0.20	268-р цэцэрлэг	
2	Хивс	Хятад	2025	ш	1	1,440,000.00	1,440,000.00	-	1,440,000.00	191-р цэцэрлэг	
4	Принтер	HP office Jet Pго 7740	2023	ш	1	1,986,600.00	1,986,600.00	1,158,850.00	827,750.00	147-р цэцэрлэг	
5	Принтер	HP office Jet Pго 7740	2023	ш	1	1,986,600.00	1,986,600.00	1,158,850.00	827,750.00	304-р цэцэрлэг	
6	Гурил зуурагч	Хятад	2024	ш	1	3,100,000.00	3,100,000.00	775,000.05	2,324,999.95	45-р цэцэрлэг	
7	Ногоо арилгагч	Хятад	2024	ш	1	1,125,000.00	1,125,000.00	618,750.00	506,250.00		
Нийт шилжүүлэх эд хөрөнгийн дүн							13,543,200.00	7,616,449.85	5,926,750.15		